

ТАНИЛЦУУЛГА

1. Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчин

Аж ахуйн нэгжийн эрх: “Хүдрэнт” ХХК нь 9011054065 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: “Хүдрэнт” ХХК-д АМГТХЭГ -ын 2013 оны 01-р сарын 30 -ны өдрийн шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хонгор-3 нэртэй газарт ашигт малтмал ашиглах MV-017256 дугаартай тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон.

Ордын нөөцийн баталгаажуулалт: ЭБМЗ-ийн 2012 оны 1-р сарын 11-ний өдрийн ХХ-01-04 тоот дүгнэлт, АМГ-ын даргын 2012 оны 1-р сарын 23-ны өдрийн 46 тоот тушаалаар В+С зэрэглэлээр батлагдсан 192872 т хүдэр, 73396.1 т хайлуур жоншны нөөцийг хүлээн авсан.


2. Төсөл хэрэгжүүлэх субъект

Төсөл хэрэгжүүлэх субъектын байршил: “Хүдрэнт” ХХК.

Ордын байршил: Хонгорын хайлуур жоншны ордын “Хонгор - IV ба VII” ордууд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км, Сайншанд хотоос баруун хойш 130 км, Даланжаргалан сумын төвөөс урагш 20 км, төмөр замын Айраг өртөөнөөс баруун тийш 28 км зайд тус тус байрлаж байна (зур.1).

Тус компанийн MV-017256 дугаартай тусгай зөвшөөрлийн 24.93 га талбайн булангийн цэгүүдийн солбицлуудыг доор үзүүлэв (зур.2).



 Хонгорын хайлуур жоншны срд

Зураг № 1. Хонгорын хайлуур жоншны ордын байршил

Тусгай зөвшөөрлийн талбайн солбицол

Хүснэгт № 2

№	Уртраг	Өргөрөг
1	108° 59' 6.67"	45° 47' 46.61"
2	108° 58' 44.67"	45° 47' 46.61"
3	108° 58' 44.67"	45° 48' 3.62"
4	108° 59' 6.67"	45° 48' 3.62"



Зураг № 2. MV-017256 тусгай зөвшөөрлийн талбай

ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Газрын гадаргуу: Физик газар зүйн хувьд энэ дүүрэг говийн хойд хэсгийн бага хэрчигдсэн дунд зэргийн өндөртэй намхан уулс, налуу дов толгодлог гадаргын хэлбэржил бүхий нутагт багтана. Хойд хэсэгт нь харьцангуй намсан 1220-1250 м өндөртэй намхан уулс зонхилох бөгөөд түүгээр Монголын төмөр зам дамжин өнгөрдөг. Хамгийн өндөр нь Хонгорын хайлуур жоншны ордоос хойт талд орших 1313.1 м өндөртэй Их Хонгор овоо уул бөгөөд зүүн хойшоо, баруун хойшлох тутам

аажмаар намсч Бор хоолой Холбоо, Айрагийн хөндийд 1000-1150 м хүрнэ. Төв болон баруун,

баруун хойт хэсэгт ижил өндөртэй, намхан уулс, жижиг дов толгодын хэлбэр зонхилно.

Ус зүй: Энэ хавьд тогтмол урсгалт гол, горхи байхгүй ба харин 200-300, хааяа 3600 л/с ундаргатай олон тооны худагтай, 40 гаруй шорвог нуур бий. Ордоос зүүн урагш орших Бужгарын цагаан, Нартын нуурууд хур тунадас болон хөрсний усаар тэжээгддэг.

Цаг уур: Тус район нь хуурай уур амьсгалтай учир жил, хоногийн температурын ялгаа ба агаарын хуурайшилт ихтэй учир унах хур тундасны хэмжээ харьцангуй бага байдаг. Хур тунадасны дийлэнх нь 6-8 саруудад ордог. Жилийн температур 0-5 хэм. Сарын дундаж температур 12, 1, 2-р саруудад -17°C-21.7°C зарим үед -35°C хүрдэг. Жилд унах тунадасны хэмжээ 150-343 мм, голдуу зун, намарт унадаг. Агаарын чийгшил өвөлд 85 % зунд 60-80 %. Анхны хүйтрэлт 9-р сарын эхээр болдог. Салхилалт голдуу хойд болон баруун хойд зүгээс 3-5 м/сек хавар 18-24 м/сек хүрдэг.

Ан амьтан: Ан амьтан цөөнтэй, туулай, зурам, оготоно гэх мэт жижиг мэргэчид, хярс, үнэг, чоно зэрэг араатан амьтад нилээд элбэг, монголд өргөн тархалттай хээрийн шувууд, (хэрээ, элээ, бүргэд, шаазгай, болжмор, чогчого, ногтруу өргөн тархалттай байдаг.

Хүн ам зүй, дэд бүтэц: Тус ордын орших районд Даланжаргалан, Хар-Айраг сумын төвүүд, төмөр замын 25-р зөрлөг Шивээговь ба Чойр хотхон, “Алтан тал” хоршоо зэрэг төв суурин газар ойр орших бөгөөд эдгээрээс хамгийн том нь Чойр, Шивээ говь хотхон юм. Шивээ говь нь төмөр замын 22-р зөрлөгөөс баруун урагшаа 2 км зайд орших ба Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглүүлэн байгуулсан орчин үеийн төрхтэй хотхон юм.

Тэнд харилцаа холбооны салбар, ахуйн үйлчилгээний төв, 12 жилийн сургууль хүн эмнэлэг засвар механикийн цех, барилга засварын газар, Шивээ Овоогийн нүүрсний уурхайн захиргаа, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагатай. Улаанбаатар хотын IV цахилгаан станцыг эрчим хүчний нүүрсээр байнга хангаж ажилладаг томоохон нүүрсний уурхай юм.

БҮЛЭГ I. ОРДЫН ГЕОЛОГИ

I.1. Геологийн судалгааны түүх

Дүүргийн судалгааны түүх нь ордын талбай урд хэсэгт 1935-1938 онуудад В.К.Чайковский 1:200000 геологийн зураглалын ажил явуулснаар эхэлсэн гэж үздэг. Тус дүүрэгт нийт янз бүрийн шатны ажлуудыг 1935-1981 он хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн байна.

Хонгор-3 талбайн Хонгор-IY, YII хайлуур жоншны ордуудад 2009-2011 онуудад Хүдрэнт ХХК өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил гүйцэтгэж хүдрийн нөөцийг (B+C) зэрэглэлээр тогтоосон.


I.2. Ордын геологийн тогтоц

Ордын хүдрийн биетүүд нь хоёр зэрэгцээ бүсэд оршино. Хойт бүс нь “Хонгор - IV” ордын хүдрийн 1-р биет, өмнөд бүс нь “Хонгор - VII” ордын хүдрийн 1-3-р биетүүдийг агуулна. “Хонгор - IV” ордын хүдрийн 1-р биет 70-72° налуутай баруун хойшоо унаж, 30° чиглэлд сунаж тогтсон байна.

Өмнөд бүсийн “Хонгор - VII” ордын хүдрийн биетүүд нь өргөргийн дагуу сунаж, урагшаа 70° уналтай. Нэлээд томоохон хүдрийн биет нь доломитжсон шохойжингийн метасоматит өөрчлөлтөөр судал үүссэн бөгөөд формац доторх давхраат хэвтэш байдлаар оршино.

“Хонгор - IV” ордын хүдрийн биет-1 нь “Хонгор - VII” ордын хүдрийн 1-р биетийн зүүн хойд салаалсан үргэлжлэл дээр гипсометрийн илүү дээд түвшинд оршино. Энэ нь шохойжингийн өөрчлөлтөөр болон хагарлын дагуу судал маягаар үүссэн гүн биш байрлалтай хүдрийн биет юм. Хүдрийн биет нь гадаргуу дээр 170 м урттай, 0.5-11.4 м, дунджаар 4.75 м зузаантай илэрсэн, бодит зузаан нь 4.48 м. Уг биет нь шохойжингийн горизонтийн зүүн хойд төгсгөлд орших бөгөөд баруун хойш 70-72° уналтай. Хэвтэш нь агуулагч чулуулагтайгаа нийцлэг байрлалтай, хүдрийн бүс нь 250 м урт, 8.0-20.0 м зузаан, босоо шахуу байрлалтай, мэшил маягийн биет юм. Хүдрийн биетийн доод зааг нь зүүн урагшаа 15 м хүртэл гүнд шургасан ба баруун урд зааг нь гадаргууд гарчээ. Хүдэр агуулагч нь филлит, хааяа шохойжин. Филлит нь хүдрийн биетийнхээ дагуу аргиллитжсан, хааяа каолинитжсан шавар үүссэн нь хүдрийн бүсийн хил зааг орчимд ажиглагдана. Энэ биетэд зүүн хойш чиглэлтэй ил малталтаар олборлолт явуулсан бөгөөд түүнд өргөргийн дагуу буюу түүнтэй ойролцоо байрлалтай эгц босоо уналтай, 10 см өргөн хагарлаар бараг шилжилтгүйгээр хэрчигдсэн байдал ажиглагдсан байна. Хүдэр нь нийтдээ ногоон-саарал шавар дотор том хэмхдэс байдлаар оршино.

Хайлуур жоншны хүдэр нь метасоматит гаралтай, нягт, хатуу, жижиг талст хөхөлбөр, хүрэн саарал өнгөтэй торлог, хэлхээслэг текстур ажиглагдана. Хайлуур жонш нь бараан саарал, саарал өнгөтэй, хааяа хөхөлбөр, ногоовтор туяатай буюу өнгөгүй байдаг. Кварцтай хам ургалт үүсгэх бөгөөд кварц нь цайвар-саарал өнгөтэй, шаазан маягийн төрхтэй, хааяа том талстлаг байна. Хайлуур жоншны дундаж агуулга нь 64.44 %. Хүдрийн биетийн зүүн хэсэгт гадаргууд шохойжингийн блокт кварцын судлууд илэрчээ.



НЭГ. БАЙГАЛЬ ОРЧИНЫ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

- Уурхайн эдэлбэр газрын агаарын бохирдолтыг аль болох бага байлгах үүднээс уурхайн авто замуудыг дулааны улиралд тогтмол услах болон тэсэлгээний үед тоосжилт бага байлгах тал дээр анхаарч цэнэгийн түгжээсэнд бутлаж бэлтгэсэн дайрга ашиглах, тэсэлгээний мөргөцгийг тэсэлгээний өмнө усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Уурхайн олборлолтонд өртөх, хөрсний гадаад овоолго уурхайн доторхи зам харилцаа барилга байгууламж зэрэгт өртөх 2.27 га буюу нийт 2.07 га талбайн үржил шимт хөрсийг урьдчилан 0.3-0.5 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах бөгөөд ордын ашиглалтын явцад болон ашиглаж дууссаны дараагаар хийгдэх нөхөн сэргээлтэнд ашиглана.
- Уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн гаргаж батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж явах бөгөөд түүнд гарах зардлыг нөхөн сэргээлт байгаль хамгаалах зардлын тооцоо хэсэгт тодорхой тусгасан болно.

- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ гацаад овоолгод дарагдах талбайг боломжит хамгийн бага байлгах зорилгод тулгуурласан байгаа.
- Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайнуудыг тусгайлан байгуулах замаар онц шаардлагагүй олон салаа зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлнэ гэж үзэж байна. Зам, талбайд ашиглагдах нийт талбайг уурхайн ашиглалт дууссаны дараагаар нөхөн сэргээнэ.

1.2 Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх талаар явуулах үйл ажиллагаа нь дараах талбаруудад чиглэгдвэл зохино.

Үүнд:

- Нөхөн сэргээлт хийгдсэн талбайг байгалийн тэнцвэрт байдлыг хадгалсан, унаган төрхөндөө орсон, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байлгах.
- Талбайн хөрсний усыг бохирдуулахгүй байх арга хэмжээ авах.
- Газрын хэвлийд үүссэн хоосон орон зай, ил уурхайн карьер зэрэгт тэмдэг тэмдэглэгээг сайн хийж өгөх,
- Уурхайн дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах явцад болон төслийн хэрэгжилтэд ашиглах хүнд машин механизм, тээврийн хэрэгслүүдийг түр болон зөвхөн зааж өгсөн замын маршрутаар явуулах, тоосжилтыг багасгах үүднээс замыг усалж байх.
- Талбайд үүсэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цэвэрлэх.
- Гал түймрээс сэргийлэн сонор сэрэмжтэй ажиллана. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг ажиллагсадад бүрэн өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалт хийж мөрдөх.
- Эвдэрсэн газрыг тарималжуулах ургамлын төрөл зүйл, тариалах арга ажиллагааг тухайн талбайн хөрсний шинж чанар, бүтэц болон газрын гадаргын налуу болон бусад нөхцөл байдалтай уялдуулан сонгох бөгөөд үр суулгац тариалах ажлыг ургамал ургах хамгийн тохиромжтой хугацаанд явуулах.

1.3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү төлөвлөгөө нь "Хүдрэнт" ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Хонгорын хайлуур жоншыг далд аргаар олборлох төслийн ашиглалтын өмнө болоод ашиглалтын үе шатанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой юм.

Мөн байгаль орчныг хамгаалах чиглэлээр аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг

- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр өөрийн ажилтан ажилчдын дунд сургалт, семинарыг улиралд нэг удаа тогтмол зохион байгуулах,
- Гал түймэр, үер усны аюул зэрэг байгалийн гай гамшгийн үед авагдах арга хэмжээний зөвлөмжийг гаргаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох,
- Байгаль орчин, хүрээлэн байгаа орчноо хайрлан хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг таслан зогсоох үзэл баримтлалыг нийт ажилтан, ажилчдын оюун ухаанд төлөвшүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон аж
- Жил бүр ажлын төлөвлөгөөндөө байгаль хамгаалах, нөхөн сэргээх сөрөг нөлөөллийг таслан зогсоох зардлыг тусган төлөвлөж ажиллах,

1.4. Байгаль хамгаалах төлөвлөгөөний агуулга

Төслийн хэрэгжүүлэх үе шат бүрд гарах гол болон сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг багасгах, нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх арга зам, зөвлөмж зэргийг багтаасан болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулсан аргачлал

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамруулан авч үзлээ. Энэхүү төлөвлөгөө нь хайлуур жонш олборлох үйл ажиллагаа явуулах хугацаанд хүчин төгөлдөр байна.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-иудыг, Байгаль орчны Сайдын тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачилсан заавар”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ” зэргийг удирдлага болгон ажиллалаа.

1.5. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө

Хөрсний бохирдол, элэгдэл:

Өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, хүдэр олборлох, тээвэрлэх, ангилан ялгах үйл ажиллагаагаар хөрс эвдэрч бохирдохоос гадна шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсэж болзошгүй. Бохирдлын эх үүсвэр нь түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг болно. Уурхайд ажиллагсад, ойр орчинд байгаа хүн, мал, бичил амьтан, ургамал амьтан зэрэг нь нөлөөлөлд өртөх объект болно. Байгаль орчинд бохирдол үүссэн тохиолдолд бохирдол нь ургамал, хөрсөөр дамжин хүрээгээ тэлэх магадлалтай. Эвдэрсэн газар, хөрсийг стандарт MNS 5917:2008-ын дагуу нөхөн сэргээнэ.

Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материал ил задгай асгахыг хориглоно. (БОЯ, ЭХЯ-ны сайдын 1989.06.22-ны 68/А/61 дугаарын тушаал).

Газар ашиглалтын бүртгэл мэдээг хөтөлж, холбогдох байгууллагад орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд тайлагнана.

Агаар орчны бохирдол:

Хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас элдэв гаж үнэр гарах, тоосжилт, утаа тортог, CO, SO₂, NO₂-ын хэмжээ ихсэж болзошгүй.

Агаарын бохирдол нь ордод ажиллагсад, ойр орчимд буй хүн, мал, амьтан, ус, ургамал, хөрсөнд нөлөөлж болзошгүй.

Эрүүл ахуйн хяналтын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдсан “Хот суурингийн агаар дахь хорт бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг” (Улсын ариун цэврийн байцаагчийн 1989 оны 11 тоот тушаалын 2-р хавсралтаар) баримтална.

Усны бохирдол:

Далд уурхайн ашиглалтын түвшин нь 1 горизонт буюу 50м-н гүнд ашиглагдах бөгөөд энэ түвшинд гүний ус илрээгүй бөгөөд уурхайн технологийн болон ундны усны хэрэгцээг хангах зорилгоор 140м гүний худаг гаргасан худгийн паспортыг хавсаргав.

Бохирдлын эх үүсвэр нь бохирдсон ус, жорлон, бохирын цэг, шатах, тослох материал, машин тэрэг угаах, ахуйн бохир ус зэрэг болно. Дээрх эх үүсвэрүүд нь гадаргын болон газар доорх усыг шууд ба шууд бусаар бохирдуулах, горимд өөрчлөлт оруулах магадлалтай. Ус бохирдоход ордод ажиллагсад, ойр хавийн хүн, мал, ан амьтан өртөх

эрсдэлтэй. Ундны усны чанарын УСТ900-92 стандарт , гадаргын болон газар доорх усны ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм , журмыг баримтална. Гадаргын болон газар доорх усны шинжилгээг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу хийлгэж байх болно.

Ургамлын бүрхэвчийн бохирдол

Бохирдолын эх үүсвэр нь автохөсөг болон бусад өөрөө явагч машин механизм дураараа зорчих, шатах тослох материал ил задгай асгаснаас үүсэх бохирдол нь ургамлын бүрхэвчийг бохирдуулах гол шалтгаан тул хамгаалалтын бүсийн дүрэм журам боловсруулж ажиллах шаардлагатай.

Ан амьтан:

Уурхайн эдэлбэр газрын орчимд амьтны аймгийн хувьд туурайтнаас цагаан зээр, махчин амьтадаас чоно, үнэг, хярс, мануул мэрэгчдээс хулгана, үхэр огодой, бозлог, туулай, алаг даахай, жигүүртнээс тас, бор бүргэд, сар, шонхор, элээ, хэрээ, харцага, тагтаа, ногтруу, болжмор, хэвлээр явагчдаас могой, хонин гүрвэл, мэлхий зэрэг ан амьтад оршино. Эдгээр амьтад нь авто техникийн дураараа зорчих болон хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж /хориотой үе болон зөвшөөрөлгүй ан амьтан агнаж устгах/ дайжих, устах аюултай тул ан агнуурын тухай хуулийн заалтуудыг нарийн мөрдөж ажиллах шаардлагатай.

Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээний төлөвлөгөө.

№	Байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм. нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал. мян. төг	Нийт зардал. мян.төг	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР										
1.	Төсөлд ашиглах машин механизм, дизель станцаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Төсөлд ашиглагдах бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж холбогдох стандарт шаардлагад нийцүүлэх	Уурхайд ашиглагдах бүх машин механизмд	ш	5	30.0	150.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	MNS 5013:2003 MNS 5014:2003
2.	Уурхайн ажиллагааны талбайгаас болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам талбайг услах тээвэрлэлтийн явцад үүсэх тоосыг дархын тулд зам талбайг байнга услах.	Карьер болон овоолго хооронд явах зам, болон бусад зам харилцаа	га	3		Үйл ажиллагааны зардалд тусгах	“Хүдрэнт” ХХК	Хуурайшилтын үед өдөр бүр услах ба бусад үед цаг уурын нөхцөлөөс хамаарна	Агаарын тухай хуулийн 9.11 23-р зүйл MNS 4585:2007
3.	Уурхайн ажил болон машин механизмын хөдөлгөөний улмаас хүрээлэн буй орчин дахь шуугианы бохирдлын түвшинг ихэсгэнэ	Машин тоног төхөөрөмжөөс үүсэж байгаа дуу шуугианыг багасгах үүднээс машин техникийн шуугианы хэмжилтийг байнга хийлгэж стандарт номд тохирохгүй техник хэрэгсэлд засвар хийх	Уурхайн ашиглалтын техник бүрд	ш	5	30.0	150.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	MNS 4599:2003
	ДҮН						300.0			

2. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ										
1.	Төслийн унд болон усалгааны хэрэгцээнд хоногт 200 л ус ашиглах тооцоо хийв. Ус хангамжийн гүний худгийн ундарга 1л/сек-ийн хүчин чадалтай	Усыг ариг гамтай хэрэглэх. Усны алдагдлыг багасгах	Уурхайг усаар хангах гүний худаг	га	20.0	Ашиглалтын зардалд тусгасан	200.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	MNS 0908:2018 ундны ус, эрүүл ахуйн шаардлага чанар, аюулгүй байдлын үнэлгээ
2.	Нефтийн бүтээгдэхүүн асгарч хөрсөнд шингэж гадаргын болон гүний усыг бохирдуулж болзошгүй	Уурхайн талбайд байгаа ШТМ аль болох асгахгүй байхаас гадна асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах ба урдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Уурхайн талбай ШТМ, засвар зогсоолын талбайд	га	20.0	50.0	100.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	Усны тухай хууль
ДҮН							300.0			
3. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ										
1.	Уурхайн ашиглалтын үеийн нөлөөгөөр үржил шимт хөрс бүхий талбайд барилга байгууламж, машин техникийн нөлөөнд орж хөрсний элэгдэл, эвдрэлд орсон, байнгын хөл хөдөлгөөний улмаас ойр орчмын хөрсөн бүрхэвч доройтох, элэгдэл эвдрэлийн талбай нэмэгдэх.	Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, олон салаа зам харгуй гаргахгүй байх, хурдны хязгаар тогтоох.	Уурхайн дотоод замууд	ш	10	20.0	200.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” “Газрын тухай хууль”

2.	Бүтээгдэхүүн тээвэрлэлтээс шалтгаалан орон нутгийн зам дагуух хөрсөн бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө.	Уурхайн талбайгаас хүдэр тээвэрлэлтийг зөвхөн баталсан тэмдэгжүүлсэн маршрутаар явуулж хэвшүүлэнэ.	Уурхайн талбайгаас Айраг ТЗ-ийн өртөө хүртэл	км	45	100.0	4500.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	Монгол улсын засгийн газрын 2018 оны 12-р сарын 12-ны 374-р тогтоол
ДҮН							4700.0			
4.УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР										
1.	уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч доройтоно.	Тосгон кемф орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлж бут сөөг, тарьж зүлэгжүүлэнэ. Хотгон дотор явган хүний зам тавина.	Уурхайн тосгон	м ²	50	100.0	500.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
ДҮН							500.0			
4. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ										
1.	Амьтны тоо толгойг бууруулах, дайжих, амьдрах орчинд нь муугаар нөлөөлөх	Зэрлэг амьтадыг хууль бусаар агнах, үргээх зэрэг үйлдэл хийхгүй хамгаалах байх талаар бүх бүрэлдэхүүнд анхааруулж сануулах.	Талбайн ойр орчмын бэлчээр нутаг	га	50	5.0	250.0	“Хүдрэнт” ХХК	Үйл ажиллагааны туршид	Амьтны тухай хууль
ДҮН							250.0			
НЭГ ЖИЛИЙН НИЙТ ЗАРДАЛ							6050.0			

Хоёр. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ордод урьд өмнө хайгуул явуулсан ил малталтуудын гарш хэсгийн ухаш, уулын ажлын улмаас бий болсон цөмрөлт, хотойлт үүссэн талбайг овоолгын чулуугаар дүүргэж тэгшилнэ. 2024 оны Уулын ажлын төлөвлөгөөгөөр 1.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх бөгөөд энэ ажилд 2.6 сая төгрөг зарцуулах бөгөөд биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй болно.

Нөхөн сэргээх талбайн хэмжээ

№	Үйл ажиллагаа	Тооцох дүн	Ажлын агуулага	Хэмжих нэгж	Нэгж зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	1.2	Дотоод овоолго	га	2.6	2,600.0	Үйл ажиллагааны туршид	Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх
2.	Биологийн нөхөн сэргээлт		хийхгүй		хийхгүй		хийхгүй	

Гурав. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хонгор-3 -ын хайлуур жоншны ордын хайгуулын ажлыг 2013 онд хийж гүйцэтгээд 2014 онд ЭБМЗ-ийн хурлаар оруулж нөөцийг батлуулсан. 2021 онд уг ордыг ашиглах ТЭЗҮ-г боловсруулж Уул Уурхайн Яамны ЭБМЗ-н хурлаар оруулж батлуулсан бөгөөд 2022 онд уг ордыг ашиглах уулын ажлын төлөвлөгөөг батлуулж үйл ажиллагаа эхэлж байгаа тул дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд Даланжаргалан, Айраг өртөө орчмын газар үүссэн хур хогийг цэвэрлэх, түүнээс үүссэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил хийхээр төлөвлөгөөг боловсруулав. Энэ ажилд 2,0 сая төгрөг төсөвлөөд байна.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Тайлбар
1.	Шууд хамгааллын арга хэмжээ			га		2,000.0	Үйл ажиллагааны туршид	Орон нутагтай тохиролцож хийнэ.
2.								

Дөрөв. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хонгор-3 -ын хайлуур жоншны гүний уурхайг 2015 онд нээж ажиллуулж байгаа бөгөөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж тооцсон болно.

Тав. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уг ордын лицензийн талбайд археологи болон палеонтологийн судалгаа 2017 онд хийгдсэн ба судалгааны тайланг үндэслэн уг зөвлөмжийн дагуу ажиллаж байна. Талбайн хэмжээнд Археологи болон палеонтологийн олдвор байхгүй.

Зургаа. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

-Уурхайн тэсэлгээний ажилд хэрэглэх химийн бодис аммонит

Одоогоор уг ордыг ашиглахдаа тэсэлгээний ажил хийх шаадлагагүй байгаа бөгөөд цаашид тэсэлгээний ажил зайлшгүй шаардлагатай нөхцөлд энэ төлөвлөгөөг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.

Аммонит нь 79% ус даах чадвартай амиакын шүү, 21%-н тортилийн хольц бүхий нэгдэл юм. Аммонит нь хий тоосны аюулгүй далд уурхайнуудад чийгтэй ба нойтон мөргөцгийн хатуу чулуулагт тэсэлгээ хийхэд зориулагдсан. Аммонит нь хүний эрүүл мэндэд дараах байдлаар үйлчилнэ.

1. Амьсгалын замаар
2. Хоол боловсруулах эрхтнээр
3. Арьс салстаар дамжин хордуулах эрсдэлд өртөх боломжтой.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Тэсэлгээний дараа агааржуулалтын ажиллагааг сайн хийх
- Аммонитийг хадгалж буй орчинд хүнсний зүйл хадгалахгүй байх
- Аммониттай харьцаж байх үед малгай, бээлий, хормогч, амны хаалт хэрэглэж байх
- Тэсэлгээний ажил явуулах үед түүний нэгдсэн дүрмийг нягт баримтлан ажиллах
- Тэсэлгээний аюулгүй бүсийн радиусыг 200м-с доошгүй зайд тогтоож ажиллах явдал нь осол гарахаас урьдчилан сэргийлж, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг багасгах үндсэн нөхцөл болно.

Аммонитийн хадгалалт

Аммонитийг хадгалахдаа дараах 2 үзүүлэлтийг голлон анхаарч аммонит хадгалах агуулахыг барина.

- Шатамхай бодис, металлуудтай хамт хадгалж болохгүй
- Халахаас хамгаалж сэрүүн хуурай газар хадгална.

Зөвшөөрөгдөх концентраций

- Аммонитийг хүн ам оршин сууж байгаа орчны агаарт зөвшөөрөгдөх хэмжээ 0.30мг/л
- Аммиакийн ажлын байрны зөвшөөрөгдөх дээд хэмжээ 20мг/л

-Усны эх булаг, усан санд байх хэмжээ 0.2мг/л

Аммонитийн учруулж болзошгүй аюул, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээ

-Аюулын бүсийг 500м-с доошгүй зайд тогтооно.

-Зөвхөн хамгаалах хэрэгсэлтэй хүн гүйцэтгэнэ.

-Гал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

-Шатах тослох материал болон бусад шатамхай материалаас зайлуулна

-Гал гарсан үед галыг ус хөөсөөр унтраана.

-Бодис асгарсан газарт элс асгаж тусгаарлана.

-Тэсрэх бодис тээвэрлэх ачиж буулгах үед аюулгүй ажиллагааны дүрмийг нягт баримтлан ажиллана. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад 1,5 сая төгрөг төсөвлөсөн.

Долоо. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэх ахуйн болон техникийн хог хаягдлыг ангилан ялгаж дараах байдлаар арга хэмжээ авна.

1. Уурхайн тосгонд үүсэх ахуйн хог хаягдал болох үнс нурам нүүрсний хог цаасан хог хаягдал хуванцар сав шилэн сав зэргийг тус тусад нь ангилан ялгаж дараах зоиулалтаар устгал хийнэ.

- Үнс нурмыг тусгайлсан нүх бэлдэж булж устгана.

- Цаас болон хуванцар шил савыг багцлан бэлдэж уурхайгаас 25 км-н зайд орших сумын төвийн хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлнэ.

2. Техникийн хог хаягдал Үүнд: Резинэн дугуй төмөр эдлэлийн хаягдал, шатах тослох материалын хаягдлууд багтана.

- Шатах тослох материалын хаягдлыг тусгай саванд хуримтлуулж дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлнэ.

- Төмрийн хаягдал резинэн дугуй зэргийг аймгийн төвийн хоёрдогч түүхий эдийн цэгүүдэд нийлүүлэх арга хэмжээнүүдийг авч ажиллана.

Хог хаягдлыг бууруулах болон устгах арга хэмжээ

№	Хийгдэх ажлууд	Нийт зардал мян.төг	Хариуцах эзэн
1	Хатуу хог хаягдлыг цуглуулах болон боловсруулах арга хэмжээ авах	50.0	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
2	Шингэн хог хаягдлыг цуглуулах болон боловсруулах арга хэмжээ авах	50.0	
3	Түр жорлон, муу усны нүх байгуулах	Байгаа	
4	Хатуу хог хаягдлын цэг байгуулах	Байгаа	

5	Хатуу болон шингэн хог хаягдлын цэг орчимд ариутгал болон халдваргүйжүүлэх ажлыг хийж байх	100.0	
	Дүн	200.0	

Найм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

- Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд Хонгор-3 -ын ордыг ашиглах төслийн нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх төсөл, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажиллана.
- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг уурхайн дарга хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.
- Нөхөн сэргээлт болон байгаль орчныг хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгнө.
- Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал Мян.төг	Хариуцагч
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоох	Жил бүр	200.0	Захирал

2	Байгаль орчны асуудлыг хариуцан зохион байгуулах үүргийг удирдлагын хүрээний ажилтандаа хариуцуулан ажиллуулах	Олборлолтын хугацаанд	500.0	Захирал
3	Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах, үйлчлүүлэх талаар тохиролцох, ажил үйлчилгээний онцлогтой холбогдон гарч болох өвчлөл, гэмтэл хордлогын тухай мэдээлэл харилцан солилцож зохих бэлтгэлийг хангах арга хэмжээ авах	Жил бүр	500.0	Захирал
4	Байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол нөлөөллийн талаар нарийвчилсан үнэлгээнд дурьдсан зөвлөмжүүдийг дэс дараатай хэрэгжүүлэн үр дүнг БОЯ, орон нутгийн зохих албадад танилцуулан зөвлөгөө авч байх	Жил бүр	200.0	Захирал
Дүн			1,400.0	

Ес. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээний ажил	Холбогдох стандартууд	Шинжилгээ хийх лаборатори	Хийх ажил
